

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 12-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-12-19

Зуунмод

Нэг. Дотоод ажил, Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Аймгийн ЗД-ын нэрэмжит үзлэг шалгалтаар бодлого хөтөлбөр, тогтоол шийдвэрийн хэрэгжилтүүдийг гаргаж үзлэгээр 90,8 %-тай дүгнэгдлээ.

Аймгийн волейболын холбооны нэрэмжит 2019 оны насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 192 тамирчин оролцож 2 насны ангилалаар өрсөлдсөн



Зуунмод сумын цолгүй залуу бөхчүүдийн барилдааныг зохион байгуулж 32 бөх барилдсан.



Төв аймгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулж буй 21 холбоодын тэргүүн нарын дунд спорт форумыг зохион байгуулж 13 холбоодын дарга, нарийн бичгийн дарга нар хүрэлцэн ирж Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг БТСГ-ын эрдэм шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн докиор профиссор Ш.Долгор шигшээ багийн сургалт дасгалжуулалтын талаар хичээл заалаа.



Хоёр. Оролцсон уралдаан тэмцээн

Хэнтийн аймагт зохиони байгууцлагдсан Борижгон дэвжээний 25 жилийн ойн барилдаанд 5 тамирчин оролцож 1 мөнгөн медаль хүртлээ.



Дархан хотноо зохион байгуулагдсан Ц.Жигдэн агсаны нэрэмжит чөлөөт бөхийн олон хотын тэмцээнд 30 гаруй багийн 600 тамирчин өрсөлдсөнөөс Төв аймгийн баг тамирчид 3 Алт, 1 мөнгө, 6 хүрэл нийт 10 медаль хүртэн багийн нэгдсэн дүнгээр 2 дугаар байр эзэллээ.



Төв аймгийн чөлөөт бөхийн өсвөр үеийн шигшээ багийн тамирчид 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр ӨМӨЗО-ны Хөх хотод ажил мэргэжил, биеийн тамирын дунд сургуулийн багтай 14 хоногийн хамтарсан бэлтгэл хийгээд ирлээ.



Төв аймгийн чөлөөт бөхийн өсвөр үеийн шигшээ багийн тамирчид Хөх хотод 14 хоногийн хамтарсан бэлтгэл хийгээд буцахдаа Дорноговь аймгийн Замын Үүд суманд болсон олон хотын тэмцээн амжилттай оролцон 4 алт 6 мөнгө 7 хүрэл медаль хүртэн багийн дүнгээр ТЭРГҮҮН БАЙР эзэллээ



Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 11-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-11-29

Зуунмод

Нэг. Дотоод ажил, Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Жаргалант суманд зохион байгуулагдсан нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийн үер 45 иргэнээс сорил судалгаа авч үнэлгээ дүгнэлт хийн, 20 иргэнд мэдээлэл өгч, 4 байгууллага, 15 иргэнд үзүүлэн тараах материал өгсөн.



Хүүхэд хамгаалалд биеийн тамирын багш нарын оролцоо сэдэвт сургалт семинарыг Аймгийн БСУГ, ГБХЗХГ-тай хамтран 2019.10.31-ны БСУГ-ын сургалтын танхимд зохион байгуулж 19 сумын 36 багш хамрагдсан.



Ахмад сагсан бөмбөгчдийн 2019 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 11-р сарын 02-ны өдөр эрэгтэй 3, эмэгтэй 2 насны ангилалаар зохион байгуулагдаж эрэгтэй 9, эмэгтэй 6, багийн 120 тамирчин оролцсон.



Сорил судалгааны баг 11-р сард 5 байгууллагын 158 хүнээс сорил судалгааг авч үнэлэлт дүгнэлт өглөө



Төв аймгийн баян сумын уугуул Монгол улсын “Гарамгай мэргэн” Монгол улсын “Харьшгүй мэргэн” Сундуйжавын Галбадрах агсаны нэрэмжит “Отго харваа-2019” тэмцээн 2019.11-р сарын 09-ны өдөр зохион байгуулж 15 аймаг, УБ хотын дүүргийн 62 багийн 496 харваач оролцлоо.



Зуунмод сумын үндэсний бөхийн холбооноос жил бүр уламжлал болгон зохион явуулдаг өсвөрийн чөлөөт бөх, үндэсний бөхийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн 2019 оны 11-р сарын 15-17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдаж 18 байгууллагын 220 тамирчин оролцлоо



Атар газар эзэмшсэний 60-н жилийн ойн хүрээнд УИХ-ын гишүүн ЗГ-ын гишүүн Батлан хамгаалахын сайд Н.Энхболдын нэрэмжит “Атарчин-2019” спортын наадам 2019 оны 11-р сарын 22-24-ны өдрүүдэд спортын 5 төрлөөр зохион байгуулагдаж 24 сумын 512 тамирчин оролцлоо.



Амар газар эзэмшсэний 60-н жилийн ойн хүрээнд 128 бахийн барилдааныг зохион байгуулж Ховд аймгийн харъяат МУ-ын харцага Б.Бат-Өлзий түрүүлэн, Төв аймгийн баянхангай сумын харъяат МУ-ын заан Б.Батмөнх үзүүрлэлээ.



Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан өдөрт зориулж Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын ивээл дор жил бүр уламжлал болгох зохион байгуулагддаг шатар сонирхогчдын анхан шатны тэмцээнийг 27 сумдад зохион байгуулан явууллаа.



Хоёр. Оролцсон уралдаан тэмцээн

Дорноговь аймгийн Иххэт” суманд болсон “Хэтийн ирээдүй-2019” өсвөрийн Жүдо бөхийн “Олон хотын” нээлттэй тэмцээнд оролцож 2 алт 2 мөнгө 1 хүрэл медаль, 2-р тамирчин 5-р байр тус тус шалгарлаа.



Төв аймгийн чөлөөт бөхийн өсвөр үеийн шигшээ багийн 20 тамирчин ӨМӨЗО-ны Биеийн тамир, Ажил мэргэжлийн сургуультай 14 хоногийн хамтарсан бэлтгэл хийж өсвөрийн тамирчдын аварга шалгаруулах тэмцээнд 5 тамирчин оролцож 2 алт, 2 хүрэл медаль хүртлээ.



Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 10-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-10-29

Зуунмод

Нэг. Дотоод ажил, Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Шинэ нисэн онгоцны буудлын ажилчдын дундах уламжлалт тэмцээнийг 10-р сарын 05-06-нд зохион явуулж 113 тамирчин, Хүүхэд хөгжил төслийн багийн тэмцээнд Зуунмод сумын 6 багийн 120 иргэд хамрагдсан.

Төв хөгжлийн лиг сагсан бөмбөгийн тэмцээний шигшээ тоглолтууд явагдаж

Бүх нийтээр мод тарих өдрөөр Зуунмод хотын цэцэрлэгт хүрээлэнд 15 ширхэг мод тарилаа.



Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, дулааны шугам хоолой, худгуудыг бүрэн янзлахад 2.200.000 төгрөг зарцууллаа.



МУ-ын хөдөлмөрийн баатар Дархан аварга Ж.Мөнхбат аваргын нэрэмжит өсвөр үе, насанд хүрэгчдийн үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 09-р сарын 28-29-ны өдрүүдэд 5 насны ангилалаар зохион байгуулагдаж 15 сумын 94 бөх тойргийн журмаар барилдлаа.



2019-10-11-ээс 12-ны өдрүүдэд Баяндэлгэр сумын спорт заалны нээлтийн ажиллагаанд зориулсан волейбол, сагсан бөмбөг, ахмадын софт волейбол гэсэн спортын 3 төрлийн тэмцээн уралдааныг зохион явуулж 198 тамирчинг хамрууллаа.



Ахмад волейболчдын аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнийг 10-р сарын 19-20-ны өдрүүдэд Угтаалцайдам суманд 35-45, 46-аас дээш насны ангилалаар зохион явуулж 6 сумын эрэгтэй 7, эмэгтэй 7 нийт 14 багийн 98 тамирчин оролцсон



Зуунмод сумын 6-н багийн ХБИ-ни дунд "Хөдөлгөөн эрүүл мэнд сэдэвт" 5-н төрлийн тэмцээнийг зохион явууллаа. Мөн иргэдийн хийсэн гар урлал ,бүтээлээр үзэглэн гаргаж харилцан туршлага солилцон ажиллаа.Нийт 42 хүн оролцож авхаалж самбаа хурд хүчээ сорин өрсөлдсөн.





Аймгийн Засаг Даргын нэрэмжит бие бялдрын сорилын уралдаан үзлэгийг 10-р сарын 25-нд зохион явуулж 13 сумын 115 хүн хамруулсан.



Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг 10-р сарын 24-нд Жаргалант суманд зохион байгуулагдаж Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 45 иргэнээс авч үнэлгээ дүгнэлт хийн, 20 иргэнд мэдээлэл өгч, тараах материал үзүүлэн 4 байгууллага, 15 иргэнд өгсөн. Соёлын төв, ЕБСургуулийн биеийн тамир талбай, спорт зааланы үйл ажиллагаа, завсарлагааны дасгалыг тогтмолжсон эсэх, багш нарын бичиг баримтын хөтлөлттэй танилцаж зөвөлгөө,



Хоёр. Оролцсон уралдаан тэмцээн

МУ-ын ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан өсвөр үеийн жү-до бөхийн тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож ХЦС-ийн сурагч 40 кг-ын жинд Ц.Лхамсүрэн хүрэл медаль



БНСУ-ын элчин сайдын нэрэмжит цомын төлөөх тэмцээн 10-р сарын 0-12-нд зохион байгуулагдаж 2 алт, 1 мөнгө 7 хүрэл медаль



Өсвөр үеийн Үндэсний бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2019.10.10-13-нд Дундговь аймагт зохион байгуулагдаж багийн дүнгээр 9-р байрыг эзэллээ.



Тайлан бичсэн
Нарийн бичиг Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 09-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-09-27

Зуунмод

Нэг. Дотоод ажил, Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI их наадмын шигшээ тэмцээнд спортын 23 төрлөөр 262 тамирчин оролцуулан 18 алт, 9 мөнгө, 24 хүрэл нийт 51 медаль хүртэж багийн дүнгээр улсын хэмжээнд 3-р байр, аймгийн хэмжээнд зохион байгуулсан ажлаараа улсад 3-р байр, сумдын сургуулиудаас Эрдэнэ сум 21 медаль хүртэж 1-р байр эзэлсэн амжилтуудыг үзүүлсэн.



GOOD NEIGHBORS MONGOLIA – 2019 кросс гүйлтийн улсын аварга шалгауулах тэмцээн 2019 оны 09-р сарын 07-нд Төв аймаг Зуунмод суманд зохион байгуулагдаж 19 байгууллагын 195 тамирчин оролцсон



Сөдөт 2019 шагайн тойром харвааг Төв аймгийн Баян-Өнжүүл суманд зохион байгуулагдаж 20 багийн 160 тамирчин оролцсон.



Зуунмод сумын 6 багийн ахмадуудын дунд граунд гольфийн тэмцээнийг зохион явуулж 6 багийн 84 ахмад хамрагдсан.



АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 08-Р САРД
ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-08-26

Зуунмод

Нэг. Дотоод ажил, өвөлжилтийн бэлтгэл

Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг гаргаж дулааны шугам сүлжээнд засвар үйлчилгээг хийж байна.



Хоёр. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Төв түмний цэнгэл-2019 баяр наадам Аргалант суманд зохион байгуулагдаж 128 бөх, шагайн харваанд 182 харваач, үндэсний сурын харваанд 35 харваан нийт 345 тамирчид оролцсон



Богд хан уулын марафон олон улсын гүйлтийн тэмцээн 2019.07.28-нд зохион байгуулагдаж 5 орны 300 гаруй тамирчид хамрагдсан.



Өлзийт нуурын шагайн 21 дэх удаагийн тойром харваа 2019.08.03-04-ны өдрүүдэд Баянцагаан суманд МУ-ын хүндэт харваач “Мэргэн долоовор” хэмээх Пунцагийн Жамсрандоржийн нэрэмжит болон зохион байгуулагдаж 18 сумын 23 багийн 184 харваач оролцлоо.



Бүжгийн тэмцээн

“ТӨВ – 2019” Спорт бүжгийн насанд хүрэгчдийн стандартын формейшны улсын аварга шалгаруулах тэмцээн 08 дугаар сарын 10-ны өдөр Биеийн тамир спортын газрын спорт зааланд зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус тэмцээнд 15 байгууллагын 280 хүн / эрэгтэй 140, эмэгтэй – 140 /оролцсон.



Байт харвааны олон улсын тэмцээн

Төв аймгийн уугуул Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Л.Жамьяасүрэн, Монгол Улсын гавьяат тамирчин Д.Дэмбэрэл нарын нэрэмжит Олон улсын байт харвааны тэмцээн 18 дахь удаагаа зохион байгуулагдаж 70 гаруй тамирчид оролцлоо.



Хөдөлгөөн Эрүүл мэнд ахмадын зүүн бүсийн өдөрлөг

Эрдэнэсант суманд Хөдөлгөөн эрүүл мэнд 2019 зүүн бүсийн ахмадын өдөрлөг 10 сумын 11 багийн дунд 4 төрлийн тэмцээн зохион байгууллаа. Нийт 140 хүн оролцсон.



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Пауэрлифтингийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах 13 дахь удаагийн тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож 6 алт, 4 мөнгө, 7 хүрэл медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 1-р байр эзэллээ.



Золбоо клубын нэрэмжит сагсан бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож хүрэл медаль хүртсэн.



Дөрөв. Сургалт, сурталчилгаа,

Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг Заамар сум, Хайлаас багт зохион байгуулагдлаа. Тус өдөрлөгт байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, нийт 7 иргэнээс бие бялдрын түвшин тогтоох сорил авч, 159 иргэний биеийн жингийн индексийг тодорхойлж, наасанд хүрэгчдийн сорил хариуцсан Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан А.Уянгатай уулзаж зөвлөн тусалж ажиллаа.



Дүгнэлт: Аймгийн БТС-ын Газраас 2019 оны 8-р сард олон улсын кросс гүйлт, бүжиг, ахмадын бүсийн өлөрлөг, нээлттэй хаалганы өдөрлөг, байт харвааны тэмцээнүүдийг зохион байгуулж нийтийг хамарсан арга хэмжээг 7 удаа зохион байгуулж, 1485 тамирчин хамруулж улсын аварга шалгаруулах тэмцээнээс 25 медаль хүртлээ.

Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 07-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-07-26


Зуунмод

Нэг. Сургалт, сурталчилгаа, гадаад харилцаа хамтын ажиллагаа

БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулагдсан БТС-ын салбарын удирдах ажилтны сургалт 2019 оны 06-р сарын 30-наас 07-р сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулагдаж дарга Д.Алтанхуяг хамрагдлаа.



БНСУ-ын Мичүхүл дүүргийн БТС-ын салбарын байгууллагуудын төлөөлөл 2019.07.24-нд Төв аймагт айлчилж спортын хэрэглэл материал тамирчин солилцоо, сургалт сурталилгааны талаар хамтран ажиллахаар тохиолцсон



Хоёр. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Зуунмод сумын аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээнийг 2019.07.03-нд зохион байгуулж 8 багийн 70 гаруй тамирчид оролцсон



Баянжаргалан сумын уугуул МУ-ын мэргэн Д.Өлзийбат агсаны нэрэмжит их сурын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2019.07.05-06-ны өдрүүдэд зохион байгуулж 18 аймгийн 28 багийн 503 харваач оролцсон



Төв аймаг байгуулагдсаны 96 жилийн ойн их баяр наадмаар сурын харваанд насанд хүрэгчдийн 110, өсвөрийн 26, шагайн харваанд 18 багийн 138 харваач, үндэсний бөхийн барилдаанд 256 бөх зодголон наадамчин олноо баясгалаа



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Уралдааны дугуйн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 07-р сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулагдаж манай баг тамирчид 2 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 1-р байр эзэлсэн.

Дүгнэлт: Аймгийн БТС-ын Газраас 2019 оны 7-р сард улсын аварга шалгаруулах тэмцээнийг 1, нийт 3 арга хэмжээг зохион байгуулж 823 тамирчин хамруулж улсын аварга шалгаруулах тэмцээнээс 7 медаль хүртлээ.

Тайлан бичсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 06-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-06-27

Зуунмод

Нэг. Сургалт, сурталчилгаа, нээлттэй хаалганы өдөрлөг


Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийг Зуунмод сумын Зүүндэлгэр баг дээр зохион байгуулж нийт 11 иргэдэд тараах материал, боршуур тарааж, байгууллагын үйл ажиллагаа, спортын секц дугуйлангын хуваарь болон иргэдэд эрүүл хооллолт, идэвхитэй хөдөлгөөний ач тус, нийгмийн эрүүл мэндийн өдрийн үйл ажиллагаандаа идэвхитэй оролцох талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.



2019 оны 05 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд БТСГ, Номын сан, Музей, Театр хамтран Баянцагаан, Баян-Өнжүүл сумдад нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж Баянцагаан сумын 63, Баян-Өнжүүл сумын 57 иргэдтэй уулзалт хийж байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч санал, гомдлыг нь хүлээн авч шинээр гарсан ажлын байрны дасгалыг зааж сурталчилгааг хийсэн.



Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Зуунмод сумын 4-р багийн 6 настай Энхжаргалын Наранжаргал хөгжлийн бэрхшээлтэй охинд БТСГ-ын гарын бэлэг гардуулсан.



ББХЧ-ийн сорил судалгааны баг Баянжаргалан суманд 2019 оны 06-р сарын 16-нд ажиллаж сумын НБ-ын ажилтан, биеийн тамирын багш, эрүүл мэндийн төвийн ажилтнуудын сорил шивсэн байдалтай танилцан заавар зөвлөмж өгч ажилласан.



Монголын тамирчдын өдөр, олон улсын олимпын өдрийг тохилдуулан Төв аймгийн БТСГ-ын нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019.06.22-ны өдөр зохион байгуулж спортын 4 төрлийн арга хэмжээнд 116 тамирчинг хамруулсан.



Хоёр. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Хүүхдийн эрхийн хамгаалан өдрөөр хөлбөмбөг 32, софт теннис 21, сагсан бөмбөг 98, үндэсний бөх 30-ийн тэмцээнүүдийг зохион явуулж 181 хүүхдэд гарын бэлэг гардуулсан.

Үндэсний сурын харвааны өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 06-р сарын 03-нд зохион байгуулагдаж 4 сумын өсвөрийн 11, насанд хүрэгчдийн 18 нийт 29 харваач оролцсон



Манлайн баясгалант үндэсний бөхийн барилдааныг Борнуур, Бүрэн сумд хамтран зохион байгуулсан.

Номт лиг хөл бөмбөгийн тэмцээнийг зохион явуулж 6 багийн 63 тамирчин оролцсон



Мини волейболын ААШТ-нд 20 сумын 58 багын 311 тамирчин оролцож улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 насны ангилалаар 24 тамирчин оролцож хагас шигшээд шалгарсан амжилтыг үзүүлсэн.



Заамар суманд боксын олон улсын тэмцээнийг зохион байгуулж 3 орны 21 байгууллагын 114 тамирчин оролцсон



Ахмадын хөдөлгөөн эрүүл мэнд өдөрлөгийг Баянжаргалан, Борнуур сумдад аймгийн Ахмадын хороотой хамтран зохион байгуулж 17 сумын 267 ахмад оролцсон.



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан таеквондогийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 4 медаль, Үндэсний сурын өсвөрийн харваачдын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт, 2 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 1-р байр, Боксын олон улсын тэмцээнээс 2 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртлээ.

Дүгнэлт: Аймгийн БТС-ын Газраас 2019 оны 6-р сард олон улсын 1, аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2, нийт 22 арга хэмжээг зохион байгуулж 2251 тамирчин хамруулж олон

улсын тэмцээнээс 7, улсын аварга шалгаруулах тэмцээнээс 9 медаль хүртлээ. НЭМ-ийн хүрээнд нарны алхалтыг 4 удаа зохион байгуулж 416 хүн оролцсон.

Тайлан бичсэн
Нарийн бичиг Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 05-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-05-29

Зуунмод

Нэг. Сургалт, сурталчилгаа

“Спорт ба хөгжил сэдэвт” төвийн бүсийн аймгуудын БТС-ын салбарын ажилчдын сургалт зөвлөгөөн 2019 оны 05-р сарын 02-04-ны өдрүүдэд Өмнөговь аймгт зохион байгуулагдан төв аймгаас 11 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо.



Нийгмийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг 4 дүгээр баг дээр зохион байгуулагдлаа. Тус өдөр нийгмийн салбарын 11 байгууллагууд үйл ажиллагаагаа иргэдэд танилцуулж, сурталчилсан. Өдөрлөгийн үеэр нийт 11 иргэдэд тараах материал, боршуур тарааж, байгууллагын үйл ажиллагаа, спортын секц дугуйлангын хуваарь болон иргэдэд эрүүл хооллолт, идэвхитэй хөдөлгөөний ач тус, нийгмийн эрүүл мэндийн өдрийн үйл ажиллагаандаа идэвхитэй оролцох талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.



Аймгийн ИТХТэргүүлэгчдийн тогтоолоор 2012 оноос аймгийн хэмжээнд долоо хоног бүрийн Лхагва гарагийг "Нийгмийн эрүүл мэндийн өдөр" болгон зарлаж, Засаг даргын 2017 оны 04 сарын А/217 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд "Нарны алхалт"-ын үйл ажиллагааг зохион байгуулж эхэлсэн. 2019 онд бид бүхэн уг арга хэмжээний цар хүрээг нэмэгдүүлэх зорилго тавьж, зөвхөн алхалт бус спортын бусад төрлүүд буюу 7 төрлийг нэмж, түүгээр хичээллэх нөхцөл бололцоог бүрдүүлэн, сум, орон нутгийн иргэдийг түлхүү хамруулахаар зорьж байна. Мөн НЭМ-ийн өдөр-ийн үйл ажиллагааг стадион буюу соёл амралтын хүрээлэнд зохион байгуулж, өглөө 06:00 цагаас 20:00 цаг хүртэл иргэдийг спортоор хичээллэх бололцоог бий болгож байна. Арга хэмжээг нийт 6 удаа зохион явуулснаас Зуунмод сумын хэмжээнд 6 багын 313 иргэн нийт 2504 ажилчин албан хаагчид иргэд, 26 сумын 1981 ажилчин

албан хаагчид иргэд Аймгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн өдрийн арга хэмжээнд нийт 4485 ажилчин албан хаагчид ард иргэд хамрагдаад байна.

Хоёр. Дотоод зохион байгуулалтын талаар

Мод тарих өдрөөр байгууллгын хашаанд 20 ш тарин байгууллагын хашаан доторх болон төв цэнгэлдэх хүрээлэнгийн хогийг цэвэрлэсэн.



Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд " KOICO" Олон улсын байгууллагаас ширээний теннис, жудо, фитнес, нийтийн биеийн тамирын чиглэлээр мэргэжилтэн багш ажиллахаар боллоо



Гурав. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Даатгуулагчдын өдрийг угтаж аймгийн Нийгмийн даатгалыни хэлтсээс уламжлал болгон зохион байгуулагддаг волейболын тэмцээнийг 2019.05.04-нд зохион явуулж 27 багийн 162 тамирчин оролцсон



Масристенгийн улсын аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг 2019.05.08-09-ны өдрүүдэд зохион явуулж 2 улсын 15 байгууллагын 121 тамирчин оролцлоо.Орсоны холбооны Саха Якут улсаас 11 тамирчин ирж оролцсон.



Хөнгөн атлетик, хүүхдийн 4-н төрөлтийн тэмцээнүүд 2019.05.11-12-нд өдрүүдэд зохион байгуулагдаж 12 сумын 15 байгууллагын 135 тамирчин оролцлоо




Хүүхдийн спортын VI их наадмын хүрээнд уулын дугуйн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019-05-12-нд зохион байгуулагдаж Эрдэнэ, Жаргалант, Архуст, Заамар, Борнуур, 5-р сургууль, Батсүмбэр, Баянчандмань сумдын 37 тамирчин оролцож 3 насны ангилалд



уралдлаа.

Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын нэрэмжит уламжлалт волейболын тэмцээн 2019.05.11-нд зохион байгуулагдаж 10 сумын 15 багийн 120 тамирчин оролцсон

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг 2019.05.15-нд зохион байгуулагдан 21 сумын 27 багийн 340 тамирчин оролцлоо.



Төв Ургац сагсан бөмбөгийн холбооны ерөнхий дасгалжуулагч, сагсан бөмбөгийн спортын мастер Д.Эрдэнэбаатар агсаны нэрэмжит насанд хүрэгчдийн сагсан бөмбөгийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 231 тамирчин оролцлоо



Ахмад багш Ц.Баттөмөр, Р.Батаа нарын нэрэмжит насанд хүрэгчид, ахмадын ширээний теннисний тэмцээнийг Аймгийн Ахмадын хороо, Баянчандмань сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж 7 сумын 580 гаруй тамирчин оролцлоо.



НЭМ-ийн өдрөөр нарны алхалтыг 5-р сард 5 удаа зохион явуулж 1200 хүнийг хамруулсан.



Дөрөв. Оролцсон уралдаан тэмцээний талаар

Багануурын цом-2019 жү-до бөхийн аварга шалгаруулах тэмцээн 2019.05.11-нд Багануур хотод болж манай тамирчид 3 алт, 6 мөнгө, 7 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр хүрэл медаль хүртлээ.



Жил бүр ялалтын баяраар уламжлал болгон зохиогддог ЗХУ-ын Баатар Д.Жанаевийн нэрэмжит 43 дэх удаагийн чөлөөт бөхийн тэмцээнд ОХУ, МОНГОЛ КАЗАКСТАНЫ 50 гаруй багийн 650 тамирчин өрсөлдсөнөөс Төв аймгийн Чөлөөт бөхийн Өсвөр үеийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцон 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.



Орхон аймагт зохион байгуулагдсан төвийн бүсийн аварга шалгаруулах таеквондогийн тэмцээнд Төв аймгийн эв нэгдэл клубын тамирчид 1 алт, 3 мөнгө, 2 хүрэл медаль хүртлээ.



Увс аймагт зохион байгуулагдсан МУ-ын хөдөлмөрийн баатар улсын аварга О.Балжиннямын нэрэмжит жү-до бөхийн өсвөр үеийн олон холтын тэмцээнээс манай тамирчид 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртлээ



Ховд аймагт зохион байгуулагдсан өсвөр үеийн УАШ жү-до бөхийн тэмцээнээс 1 хүрэл медаль хүртлээ



АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 04-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-04-26

Зуунмод

Нэг. Сургалт, сурталчилгаа



Биеийн тамирын багш, сурагчдын олимпиадыг 2019.04.10-нд зохион байгуулж 44 багш, 55 сурагч оролцож, онолын болон бие бялдрын шалгалтуудыг өгсөн.



Биеийн тамирын багш нарын сургалт семинартыг 2019.04.11-нд зохион явуулж 20 сумын 41 багш хамрагдсан



Зуунмод сумын 2-р багт нээлттэй хаалганы өдөрлөгийн зохион явуулж



Хоёр. Дотоод зохион байгуулалтын талаар

УИХ-ын гишүүн М.Энхболд Зуунмод суманд 640 хүүхдийн спортын төрөлжсөн сургалттай дунд сургуулийн барилгын шав тавилаа.



Мал төллөлтийн үед мал бүхий иргэдэд туслах зорилгоор жижүүр Б.Дашдаваад 10 хоног арга зүйч Д.Мөнх-Эрдэнэд 3 хоногийн цалинтай чөлөө олгож Баянцагаан, Бүрэн сумдад ажиллуулж 217 төл мал хүлээн авсан.



Олимп, Дэлхийн аварга алдарт бөх Роман Михайлович Дмитриевичийн нэрэмжит ОХУ-ын Саха улсын Биеийн тамирын их сургуультай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Төв аймгийн есвэр үеийн шигшээ багийнхан хамтарсан бэлтгэл, багш дасгалжуулагч солилцоо харилцан туршилга судлах зэрэгт ажиллахаар боллоо.



Гурав. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Ахмадын хийн дасгалын тэмцээнийг 2019.03.27-нд Зуунмод сумын 6-н багийн дунд зохион явуулж 6 багийн 120 ахмад хамрагдсан.

Нийгмийн бодлогын хэлтсийн даргын нэрэмжит нийгмийн салбарын байгууллагуудын ажилчин албан хаагчдын дунд зохиогдсон нөхөрсөн тэмцээнийг 2019 оны 03-р сарын 30-31-ны өдрүүдэд анх удаа зохион явуулж 11 байгууллагын 10 багийн 120 гаруй ажилчин албан хаагчид хамрагдлаа.



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Булган аймагт 201-03.30-31-ны өдрүүдэд зохион байгуулагдсан төвийн бүсийн аварга шалгаруулах жү-до бөхийн тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож 1 алт, 3 хүрэл медаль хүртлээ.



Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан самбо бөхийн өсвөр үеийн УАШТ-нд тамирчин С.Очиртуяа охидын -30 кг жинд “Хүрэл” медаль хүртлээ.



Их эзэн ЧИНГЭС ХААНЫ өлгийн нутаг Хэнтий аймагт болсон Дархан аварга Ж.МӨНХБАТЫН нэрэмжит чөлөөт бөхийн 2019 оны өсвөр үеийн УАШТ-нд 39 байгууллагын 500 гаруй тамирчид оролцсоноос Төв аймгийн баг тамирчид 2 мөнгөн медаль хүртэн 5 хүүхэд хүрэл медалийн төлөө өрсөлдөн шагналт 5-р байранд орж багийн дүнгээр эрэгтэй баг 46 оноогоор 3-р байранд шалгарч хүрэл медаль хүртлээ.



2019.04.17-26 хооронд Турк улсад зохиогдсон Сурагчдын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсаа төлөөлж Төв аймгийн Эрдэнэсант сумын тамирчин Г.Сүхбат 15 насны аэнгилалд 3-р байр хүрэл медаль хүртлээ.



Тайлан бичсэн
Нарийн бичиг Д.Энхцэцэг

Нэг. Дотоод зохион байгуулалтын талаар

Байгууллагын орчин тойрны харуул хамгаалалтыг сайжруулах зорилгоор 8 камер шинээр байрлуулж үйл ажиллагааг хянаж байна.



Хоёр. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Жаргалант сумын нэрэмжит 2019 оны аймгийн аварга шалгаруулах идэрчүүдийн волейболын ААШТ 2019.03.01-03-ны өдрүүдэд Төв аймгийн Жаргалант суманд зохион байнгуулагдаж 12 сумын охидын 19, хөвгүүдийн 16, нийт 35 багийн 270 тамирчин оролцлоо



Төв аймгийн Баян-Өнжүүл сумын харъяат МУ-ын ардын багш, улсын арслан гавъяат дасгалжуулагч Л.Сосорбарамын нэрэмжит 2019 оны ААШ жү-до бөхийн тэмцээн 2019.03.01-02-нд болж 17 байгууллагын 207 тамирчин оролцлоо



Монгол улсын гавъяат тамирчин, Дэлхийн хошой аварга, дэлхийн залуучуудын аварга, дэлхийн цомын аварга, дэлхийн “Шилдэг босоо бөх” цомын эзэн Ганхуягын Үүрцолмонгийн нэрэмжит Самбо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 15 байгууллагын 140 тамирчин оролцлоо:



100-н буудалт даамын ААШТ-ийг 2019.03.02-ны өдөр зохин явуулж 8-н сум сургуулийн 109 н өсвөрийн тамирчин хүүхэд Насанд хүрэгчид 21 н тамирчид оролцсон



Энх мэндийн харваа -2019” шагайн харвааны тэмцээн 2019.03.09-нд зохион байгуулагдаж 16 аймгийн 78 багийн 606 багийн харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.



Баянчандмань сумын нэрэмжит ширээний теннисний ААШ тэмцээнийг 2019.03.10-ны өдөр өсвөр үе 4 нас, залуучууд, насанд хүрэгчид, ахмад гэсэн ангилалаар зохион байгуулж 7 сумын 129 тамирчин оролцлоо.



“Шилдэг жү-до -2019” жү-до бөхийн олон хотын тэмцээнийг 2019.03.16-17-ны өдрүүдэд зохион явуулж 26 байгууллагын 420 гаруй тамирчид оролцлоо.



Гурав. Оролцсон уралдаан тэмцээн

Монголын хүүхдийн спортын VI их наадмын тэшүүрийн тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож 8 алт, 2 мөнгө, 5 хүрэл нийт 15 медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 2-р байрыг эзэллээ.



Монголын хүүхдийн спортын VI их наадмын цанын тэмцээнээс 3 алт, 11 мөнгө, 7 хүрэл нийт 21 медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 2-р байрыг эзэллээ.



Монголын бүх ард түмний XV спартакиадын өвлтцийн төрлөөр Төв аймаг улсын хэмжээнд 3-р байр эзэлж 4 сая төгрөгөөр шагнууллаа.



Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан олон улсын өсвөрийн аварга шалгаруулах тэмцээнээс чөлөөт бөхийн барилдаанд манай баг тамирчид амжилттай оролцож 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр эзэлсэн.



Классик пауэрлифтингийн улсын аварга шалгаруулах тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож 4 алт, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр эзэлсэн.



Тайлан хийсэн

Нарийн бичиг

Д.Энхцэцэг


ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-02-28

Зуунмод

Нэг. Дотоод зохион байгуулалтын талаар

Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, гадна пасад, гэрлэн чимэглэл хийх зорилгоор өөрийн нөөц бололцоогоо ашиглан 2018 оны нэмэлт санхүүжилтийн үлдэгдлээс үүдний гэрэлтүүлгийг нэмэгдүүлж байгууллагын гадна дотор талд 8 камер байрлуулахад 2.100.000 төгрөгийг зарцууллаа.



Баянчандмань сумын харъяат аймгийн хурц арслан Э.Ууганбар 2018 оны хөдөлмөрийн аварга тамирчнаар шалгарч 20-р сарын 04-нд ирж шагналаа гардан авлаа



Хоёр. Сургалт сурталчилгаа

Чөлөөт бөхийн өсвөрийн шигшээ багийн тамирчид, дасгалжуулагчид Баянцогт суманд ажиллаж хамтарсан бэлтгэл сургуулилт, 2 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Гурав. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

“ЗУУНМОДНЫ ХҮЧТЭН-2019” пауэрлифтингийн тэмцээн 2019.02.02-03-ны өдрүүдэд зохион байгуулагдаж Өмнөговь, Дундговь, Дорнод, Булган, Сэлэнгэ, Хэнтий, Улаанбаатар, Налайх, Багануур дүүрэг, Төв аймгаас 100 гаруй тамирчид 3 насны ангиллаар хүч сорин өрсөлдлөө.

УБЦТС ХК-ын Зуунмод түгээх төвийн нэрэмжит Сар шинийн баярт зориулсан өсвөр үеийн үндэсний бөхийн барилдаан 2019-02-02-нд 17-18, 16-аас доош насны ангилалаар Зуунмод суманд зохион байгуулагдаж 9 сумын 41 тамирчин оролцлоо.



Хүүхдийн спортын VI их наадмын хүрээнд 2019 оны 02-р сарын 02-03-нд зохион байгуулагдсан аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн өсвөр үе 5-6, 7-8, 9-10, 11-12, 13-14, 15-16, 17-18 нас, насанд хүрэгчид, ахмад гэсэн ангилалаар 2019-02-02-03-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 17 сум сургуулийн 166 тамирчин оролцсон.




Хүүхдийн спортын VI их наадмын хүрээнд зохиогдсон цанын өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2019 оны 02-р сарын 14-нд төв аймгийн Жаргалант суманд зохион байгууллаа. Тэмцээнг Жаргалант, Борнуур, Заамар сумдын 32 тамирчин оролцлоо.



БТС-ын тэргүүний ажилтан ахмад багш Э.Зоригийн нэрэмжит Зуунмод хотын аварга шалгаруулах чөлөөт бөхийн барилдааныг 2019 оны 02-р сарын 16-нд амжилттай зохион байгуулж 4 байгууллагын 80 гаруй тамирчид охид 4, хөвгүүд 8 жинд хүч сорин өрсөлдлөө.



МУ-ын гавъяат дасгалжуулагч, улсын арслан Ө.Эрдэнэ-Очир агсаны нэрэмжит 2019 оны чөлөөт бөхийн барилдааны аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээн 2019-02.23-ны өдөр зохион байгуулагдаж 17 сумын 21 багийн 300 гаруй тамирчид, МУ-ын ардын багш, улсын харцага Д.Сэрээтэрийн нэрэмжит залуучуудын аймгийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн барилдаан 2019.02.-24-нд зохион байгуулагдаж 14 сумын 20 багийн 100 гаруй тамирчид оролцлоо хурд хүчээ сорилоо.



Эх орончдын өдөрт зориулсан “Манлайн баясгалант” үндэсний бөхийн барилдааныг Баянцогт сум, Баянчандмань сумдын ЗДТГ, ИТХ-ын ажлын албатай хамтран 64 бөхийн барилдаанд Баянчандмань сумын харъяат Э.Ууганбаяр түрүүлэн Баяндэлгэр сумын харъяат улсын начин Б.Батчулуун үзүүрлэж Баянхангай сумын улсын заан Б.Батмөнх, Сүмбэр сумын улсын начин Г.Ганжард нар үзүүрлэлээ.



Дөрөв. Оролцсон уралдаан тэмцээн

УБ хотын аварга шалгаруулах тэшүүрийн тэмцээнд манай баг тамирчид амжилттай оролцож 12 медаль хүртэж багийн дүнгээр 2-р байр эзэллээ.



Өсвөрийн шатарчдын улсын аварга шалгаруулах тэмцээн 2019.02.23-24-нд УБ хотноо зохион байгуулагдаж Эрдэнэсант сумын сурагч Г.Сүхбат 12-13 насны ангилалд хүрэл медаль, Баянцогт сумын сурагч А.Бат-Эрдэнэ 4-р байрт шалгарлаа



Тайлан бичсэн
Нарийн бичиг Д.Энхцэцэг

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРААС 2019 ОНЫ 01-Р САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ

2019-01-30

Зуунмод

Нэг. Дотоод зохион байгуулалтын талаар

Бүх ажилчидтай хөдөлийн гэрээг байгуулах бэлтгэл ажлыг ханган багш дасгалжуулагчид ажилчид жил улирлын ажлын төлөвлөгөө, секц дугуйлангийн төлөвлөгөө, хуваарийг батлуулан ажиллаж байна.

2019 оны уралдаан тэмцээний нэгдсэн заавар удирдамжийг батлан сум, сургуулиудад хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг байгуулсан.

Хоёр.Сургалт сурталчилгаа

Төрийн албаны шинээр батлагдсан хуулийн талаар Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн хүний нөөцийн мэргэжлтэн Г.Мөнхгэрэл 2019-01-23-нд ирж сургалт зохион байгуулж 19 хүнээс 12 ажилтан албан хаагчид оролцлоо.



Гүрав. Зохион байгуулсан уралдаан тэмцээн

Монголын масристингийн холбоотой хамтарч Арнольд Классик тэмцээний сонгон шалгаруулах тэмцээнийг 5 жингийн ангилалаар 2019-01-06-нд Зуунмод суманд зохион явууллаа. Тэмцээнд УБ, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Хэнтий аймгуудын 30 гаруй тамирчид оролцов.



МШХХ-ны 2018 оны шилдэг салбар зөвлөлөөр Зуунмод сумын шагайн харвааны зөвлөл шалгарч 2019 оны нээлтийн харвааг 2019 оны 01-р сарын 05-нд зохион байгуулж 9 багийн 70 гаруй харваач оролцлоо.



ББТА, АБТА, ахмад багш Ц.Гомбын нэрэмжит баруун бүсийн өсвөрийн тамирчдын аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээн 2019-01-12-13-нд зохион байгуулагдаж 8 сумын 100 гаруй өсвөрийн бөхчүүд 10 жинд өрсөлдсөн.



Монгол улсад шинэ үндсэн хууль батлагдсаны 27 жилийн ойд зориулсан “Манлайн баясгалант” үндэсний бөхийн барилдааныг 2019-01-11-ны өдөр зохион байгуулж 40 бөх барилдсанаас Төв аймгийн Өндөрширээт сумын харъяат Аймгийн арслан Б.Хүдэрбулга түрүүлж, Төв аймгийн Баягцогт сумын харъяат МУ-ын харцага Ө.Даваабаатар үзүүрлэн Сүмбэр сумын харъяат МУ-ын начин Г.Ганжад шөвгөрсөн.





МУ-ын гавьяат тамирчин О.Энхтайваны нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг Баянчандмань суманд зохион байгуулж 9 сумын 80 гаруй өсвөрийн бөхчүүд оролцсон



Тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээнийг 2019.01.31-нд Хандгайтын мөсөн гулгуурын талбайд зохион байгуулж Төв, Булган, Орхон, Алдар спорт хороо, УБ хотын БЗД, ХУД-ийн 31 тамирчин 3 насны ангилалаар өрсөлдлөө.




Хоёр. Оролцсон уралдаан тэмцээн

Дархан хотноо зохиогдсон U17 улсын аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд ХЦС-ийн 12-р ангийн сурагч Б.Шинэбаяр нь амжилттай оролцож шилдэг тоглогчоор шалгарлаа



Хэнтийн аймгийн Дадал суманд 2019.01.25-27-нд зохион байгуулагдсан өсвөрийн цаначдын УАШТ-нд манай баг тамирчид 8 алт, 12 мөнгө, 2 хүрэл бүгд 22 медаль хүртэж багийн дүнгээр 2-р байр эзэллээ.



Хэвтээ шахалтын улсын аварга шалгаруулах тэмцээн 2018.01.23-27-ны өдрүүдэд УБ хотноо зохион байгуулагдаж манай тамирчид 3 алт, 5 мөнгө, 6 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 2-р байр эзэллээ.



Тайлан бичсэн
Нарийн бичиг Д.Энхцэцэг